



**ХЭНГИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/34

Баян-Адарга

Г

Т

**Газар эзэмшүүлэх эрх
шилжүүлэх тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг 66,3 дэх хэсэг, 59 дүгээр зүйлийн 59.1.16 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэг, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн хүсэлт гаргасны дагуу Шагдарсүрэн овогтой Эрдэнээгийн Адрага 3 дугаар багийн Дэв нарс хаягт байрлах Өвөлжөө, хаваржааны зориулалттай 2307001921 нэгж талбарын дугаар бүхий 10000 квадрат метр газрын эзэмших эрхийг Эрдэнээ овогтой Отгоншаравд шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлж, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газрын тухай хууль болон гэрээнд заагдсан заалтуудын дагуу эзэмшихийг Э.Отгоншаравд үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Очирбат)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2009 оны А/40 тоот захирамж болон 0000408329 тоот газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ЛХАГВАДОРЖ